


Бөхөнгийн Мэдээ



2005 зун: дугаар 1

Владимир Смирин зурав

Бөхөнгийн экологи, хамгааллын талаар мэдээлэл солилцох 4 хэл дээр гарах мэдээ

Гарчиг

Сэдэвт өгүүлэл - Хуудас 1
Бөхөнгийн популяциудын генетик ялгаа

Редакцийн үг - Хуудас 2

Шинэ мэдээ - Хуудас 3
Бөхөнгийн талаарх олон улсын хурлууд

Монгол бөхөнгийн байдал олон улсын мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж байна.

“Хүүхдүүд зурж байна” – Халимагт бөхөнгийн сэдэвт зургийн уралдаан болов.

“Бөхөн хүүхэдэйн кино” Казахстаны Астанад болсон үзэсгэлэн

Францийн телевизээр бөхөнгийн тухай кино үзүүлэв

Хятадад бөхөн сэргээн нутагшуулж буй мэдээ

Бөхөнгийн тухай мэдээ – Хуудас 4-5
Казахстан
Г.Наумова: Бөхөнгийн янзаганы нам гүм байдал Новое Поколение 2004 оны 6 сарын 4

Монгол
Б.Булгамаа: Судалгаагаар бөхөн мөхлийн ирмэгт тулсныг тогтоожээ. “UB post”. 2004 оны 4 сарын 8.

Узбекистан
В.Бочин: “Бөхөнг хамгаалж болно”. Правда Востока. 2004 оны 10 сарын 14.

Бөхөнгийн талаарх сүүлийн үед хэвлэгдсэн нийтлэлүүд: Хуудас 5

Өгүүллүүд – Хуудас 6-7
Айли Канг: Хятадын уламжлалт анагаах ухаанд Бөхөнгийн эврийг ашиглах нь

Жумамурад Сапармурадов: Туркменистаны бөхөнгийн өнгөрсөн ба одоогийн байдал.

Төслийн эргэн тойронд – Хуудас 7-8
“Бетпақдал дахь бөхөнгийн хамгаалал (Казахстан)”


“Бөхөнг хамгаалж орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах нь”

“Нэн ховор бөхөнгийн Узбекистан дахь тархац нутагт хийсэн нийгэм эдийн засгийн судалгаа”

“Нэн ховор бөхөнгийн нөхөн үржихүйн экологи”

Бөхөнгийн популяциудын генетик ялгаа

Судлаачдын дунд бөхөн (*Saiga tatarica*)-гийн генетик вариаци олон жилийн турш маргаантай асуудал хэвээр байсан. Монгол дахь бөхөнгийн популяцийн тархац нутгийн хүрээнд морфологи болон экологи нөхцөл байдлаар ялгаатай бөхөнгийн дэд зүйлийг илрүүлжээ (зураг дээрээс эврийн морфологийн ялгааг харна уу). Монгол бөхөнгийн одоогийн байдал (Л.Амгалан 2003 онд 750 соргог бөхөн тоолжээ) нь энэ дэд зүйл мөхлийн ирмэгт тулсныг олон улсын нийгэмлэгт үзүүлэх, генетикийн хувьд ямар ялгаатайг мэдэх нь чухал юм. Өөр нэг асуудал бол дэд зүйлийн хэмжээнд генетикийн хувьд ялгаатай дөрвөн популяци байна. Бөхөнгийн тоо толгой маш бага Бетпақдалагийн популяцийн хувьд мөхөж улмаар генетикийн олон янз байдал хомсдолд орох аюултай. Бөхөнг гаршуулан өсгөх болон популяциудыг хооронд нь шилжүүлэн байршуулах хоёрын аль чухал бэ? Эдгээр асуултанд хариулахийн тулд INTAS төслөөс судалгааны ажлыг дэмжин ажиллаж байна.



Эр бөхөн:

а) Бөхөнгийн дэд зүйл болох *S.t.tatarica*

б) Монгол бөхөн



Марина Холодова бусад судлаачидтай хамтран одоогийн таван популяциас цуглуулсан дээжийг Москвагийн Экологи, эволюцийн хүрээлэнд шинжилсэн ба судалгаанд Английн Ворвикийн Их Сургууль (Дарвиний санаачлага төслөөр санхүүжигдсэн) болон Сан Диегогийн амьтан судлалын нийгэмлэг хамтран техникийн тусламж үзүүлсэн. Судалгааны ажлыг Оросын суурь судалгааны сангаас санхүүжүүлж дараах үр дүнд хүрэв:

- Монголоос цуглуулсан дээжүүд нь *Saiga tatarica tatarica* дэд зүйлээс генетикийн хувьд бага зэрэг ялгаатай байсан хэдий ч генетик олон янз байдлаараа бага байна. Судалгаа нь монгол бөхөнгийн популяцийн генетик ялгаа нь ангилал зүйн хувьд дэд зүйл гэдгийг баталж байгаа боловч энэ нь бусад бөхөнгийн популяциудаас генетикийн хувьд тийм ч ялгаатай бус байна.

- Бөхөнгийн бусад дөрвөн популяци нь генетикийн хувьд ялгаагүй юм. Харин ижил мөрний зүүн хэсэг болох казахстан, узбекистан дахь бөхөнгийн популяциуд нь хэд хэдэн гаплотип бүхий ижил хромосомтой байхад халимаг дахь бөхөнгийн популяцид ижил хромосом ажиглагдсангүй. Энэ нь халимагийн бөхөн генетикийн хувьд бусад популяциудаас илүү ялгаатайг харуулж байж болох юм. Цуглуулсан дээжний хэмжээ бага байсан.

- Бөхөнгийн дээрхи бүх популяциуд өвөрмөц гаплотип бүхий хромосомтой байлаа. Генетикийн хувьд өвөрмөц энэ шинж чанарууд нь генетик олон янз байдлыг хадгалан үлдэх нөхцөл бүрдүүлсэн ба эдгээр популяциудыг генетикийн хувьд ялгаатай нэгжүүд байдлаар авч үзэн хамгаалах үйл ажиллагааг явуулах хэрэгтэй.

- Бүх тохиолдолд (монгол бөхөн оролцуулан) популяциудын доторх бодгалиудын генетик ялгаа нь популяци хоорондын генетик ялгаанаас илүү байсан. Түүхэн цаг үед өргөн тархалттай, нүүдэллэдэг шинж чанар нь бөхөнгийн эдгээр популяциуд генетикийн хувьд нэг ижил гетероген популяциас тусгаарлан салсан болохыг харуулж байна.

Дээрхи мэдээллийг “Нэн ховордож буй бөхөнгийн популяцийн генетик” хэмээх М.В.Холодова, Е.Ж.Милнер-Гулланд, А.Ж.Истон, Л.Амгалан, Лу.Н.Арилов, А.Бекенов, Лу.А.Грачев, А.А.Луцкеина, О.Райдер нарын бүтээлээс иш татав. Илүү мэдээлэл авахыг хүсвэл:

mvkhold@hotmail.com

Редакцийн зөвлөл. Хятад: Доктор А.Канг, WCS-ын Хятад дахь салбар (ygling@online.sh.cn); Казахстан: Профессор А.Бекенов, доктор Лу.А.Грачев, Амьтан судлалын хүрээлэн (teroi@nursat.kz); Монгол: Доктор Б.Лхагвасүрэн, доктор Л.Амгалан, Биологийн хүрээлэн (ecolab@magicnet.mn), Ё.Онон, ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар; Орос: Профессор Ю.Арилов, Халимаг улсын Зэрлэг амьтны төв, доктор А.Луцкеина, Экологи ба (opon@wwf.mn) Эволюцийн хүрээлэн (mab.ru@relcom.ru); Туркменистан: Доктор Д.Сапармурадов, Цөлийн амьтан, ургамлын хүрээлэн (desert@online.tm); saparmuradov@mail.ru); Узбекистан: Доктор Е.Быкова, доктор А.Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esip@tk.uz); Нэгдсэн вант улс: Доктор Е.Ж.Милнер-Гулланд, Лондоны эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бөхөнгийн талаархи мэдээ, материалыг Англи, Орос, Монгол хэл дээр хүлээн авна. Мэдээ, материалуудаа esip@tk.uz хаягаар илгээх юмуу эсвэл редакцийн зөвлөлийн гишүүдийн хаягаар хандаж болно. Бид жилд хоёр дугаар гаргана.

Хэвлэгдсэн нийтлэлүүдийг <http://saigak.biodiversity.ru/publication.html> юмуу www.iccs.org.uk/saiganews.html хаягуудаар нэвтрэн орж pdf файл хэлбэрээр авах ба хэвлэлийн эхийн хуулбарыг Англи, Орос, Хятад, Монгол аль хүссэн хэл дээрээ авч болно.



Монгол хувилбарыг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар, ШУА-ийн Биологийн хүрээлэн хамтран хэвлүүлэв.

Редакцийн үг

Бөхөнгийн хамгаалал, түүний талаар сонирхсон хүмүүс 6 сар тутамд хэвлэгдэн гарах интернет сэтгүүл болох “Бөхөнгийн мэдээ” (“Saiga news”) -ний анхны дугаарт тавтай морилно уу! Бид нар хэвлэл захиалагчиддаа өргөн хүрээтэй үйлчилж байгаа бөгөөд орон нутгийн болон олон улсын чанартай бөхөн хамгаалах үйл ажиллагааг олон нийтэд сурталчлахын төлөө ажиллаж байна. Бидний зорилго бол хүн бүрт зориулан бөхөнгийн талаарх үнэн зөв, хэрэгцээтэй мэдээ материалыг Англи, Орос, Монгол, Хятад хэл дээр хэвлэн гаргах явдал юм.

Бид бөхөнгийн төлөө гэсэн сэтгэлтэй хүмүүсийн дэмжлэггүйгээр амжилтанд хүрч чадахгүй билээ. Иймээс бөхөнгийн талаар бусдад хэрэг болохуйц, хэрэгтэй гэсэн сонин сэтгүүлийн хайчилбар, шинэ соргог мэдээ, эсвэл өөрийн судалгааны мэдээлэл, өгүүллийг бидэнд илгээнэ үү. Та бүхэн “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийг худалдан авах, найз нөхөд, хамтран ажиллагсадтайгаа хэрэгцээтэй мэдээ мэдээллийг хуваалцахыг хүсвэл бидэнд өөрсдийн хаягаа илгээнэ үү .

Бид сайн дурынхан ба энэхүү сэтгүүлийн эхний дөрвөн дугаарыг нийтлэхээс өөр төсөв хөрөнгөгүй байна. Бага хэмжээний санхүүгийн туслалцаа бидний үйл ажиллагаанд их тус нэмэр болох ба бид сонин хэвлэн нийтэлж өөрийгөө санхүүжүүлэх, мөн сэтгүүлийн хуулбарыг бөхөн тархсан улс орнуудад зориулан нэмж хэвлэх зэрэгт нэмэлт цаг заваа зарцуулах болно. Хэрэв та боломжтой бол “Бөхөнгийн мэдээ” сонинг захиалан бидний ажилд тусална уу. Захиалгыг доорхи маягаар хийнэ үү.

Редакцийн зөвлөл

Холбоо барих: Елена Быкова esip@tkt.uz

Бөхөнгийн мэдээ сэтгүүлийн захиалга

Бөхөнгийн мэдээ сэтгүүл нь жилд 2 дугаар гарах ба захиалгын үнэ хувь хүнд 10 фунт стерлинг (20 ам.доллар), харин албан байгууллагад 50 фунт стерлинг (100 ам.доллар) тус тус байна. Захиалагч тус бүрийг удахгүй гарах дугаарын талархалд бичнэ.

Би “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийн дугаарыг захиалж Лондоны Эзэн хааны коллежид (Imperial College) банкны чек, эсвэл хуулбарыг шилжүүлэв.

Би дараах хэлбэрээр “Бөхөнгийн мэдээ” сонинг захиалмаар байна (бөглөнө үү):

- E-майл (Pdf format)
- Хэвлэсэн тухай мэдээллийг вэб холбоосын хамт e-майл-ээр
- Шуудангаар

Нэр:

Шуудангийн хаяг:

E-mail хаяг:

Энэхүү хуудсыг төлбөрийн хамт дараах хаягаар илгээнэ үү:

E.J. Milner-Gulland, Division of Biology, Imperial College London, Manor House, Silwood Park, Ascot, SL5 7PY, UK.

e-mail: e.j.milner-gulland@imperial.ac.uk

Шинэ мэдээ

Олон улсын ба Орон нутгийн

Олон улсын уулзалтууд бөхөнд ач холбогдол өгч байна.

2004 оны 10 сарын CITES-ийн талуудын XIII их хурал болон 2004 оны 11 сарын Олон улсын байгаль хамгаалах конгресс зэрэг хурлуудаар бөхөнгийн талаа

WCC-ийн шийдвэр: http://www.iucn.org/congress/members/adopted_res_and_rec/REC/RECWCC3113%20-%20REC031E-Rev1%20Final.pdf

CITES-ийн шийдвэр: http://www.cites.org/eng/dec/valid13/13-27_35.shtml



Монгол бөхөнгийн байдал олон улсын мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж байна: 2004 оны 10 сар, Улаанбаатар

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дах хөтөлбөрийн газар Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*)-гийн талаар уулзалтыг зохион байгуулав. Энэхүү уулзалт нь ховордож буй бөхөнгийн хувьд цагаа олсон хэрэг байлаа. Сүүлийн жилүүдэд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дах хөтөлбөрийн газар монгол бөхөнг хамгаалах талаар олон ажил зохион байгуулсан нь бодитой үр дүнд хүрсэн. 2002 оны байдлаар Монгол бөхөнгийн популяцийн хэмжээ хамгийн их буюу 5000 хүрч, Том өвсөн тэжээлтний сангаас санхүүжүүлсэн төслөөр орон нутгийн иргэд бөхөнг хамгаалах ажилд идэвхтэй хамтран оролцдог болсон. Харамсалтай нь төслийн санхүүжилт дууссанаас хойш хахир өвөл болон хулгайн ангийн нөлөөгөөр бөхөнгийн тоо толгой эрс багасч 2004 оны хаврын байдлаар 750-д хүрчээ. Уулзалтаар бөхөнгийн популяцид 2004/5 онд учирч болох зудын нөлөө холбогдлын тухай анхааран ярилцсан ба, засгийн газарт өгөх зөвлөмжид цаг уурын хатуу ширүүн нөхцлийн нөлөөг багасгах, бөхөн хамгаалах үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх саналууд давамгайлсан байна. Английн Дарвиний санаачлага төслийн хүрээнд “Бөхөн хамгааллыг түшиглэн нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах” талаар Халимаг, Казахстанд хийж буй хамгааллын чадавхийг нэмэгдүүлэх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхтэй холбоотой илтгэлүүд тавилаа. Халимагт бөхөнг амжилттай гаршуулан үржүүлж байгаа талаар мэдээлсэн ба Монголд үүнтэй төстэй нөхцлийг бий болгон хамтран ажиллах нь хамгийн чухал гэдгийг цохон тэмдэглэлээ.

Монгол бөхөн урт хугацааны турш олон улсын хамгааллын хүрээнд гадуур явж ирсэн ба энэ дэд зүйлийг устах аюулд орохоос өмнө нөхцөл байдлыг өөрчлөх хэрэгтэй. Монгол бөхөнгийн тоо толгойг нөхөн сэргээх, хамгааллын талаар харилцан ашигтай ажиллах тухай удахгүй болох Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах олон улсын конвенцийн (CMS) Харилцан ойлголцлын баримтанд Монголын тал гарын үсэг зурж, Элистад 2002 онд баталсан бөхөн хамгааллын үйл ажиллагааны төлөвлөгөөнд Монгол улс нэгдэх нь зүйтэй гэж үзлээ.


Илүү мэдээлэл авахыг хүсвэл:

<http://www.wwf.mn/documents/Recommendation%20from%20Internatioanl%20saiga%20Workshop.pdf>



“Хүүхдүүд зурж байна” Халимагт болсон бөхөнгийн сэдэвт зургийн уралдаан.

Халимагт бөхөнгийн сэдэвт гар зургийн уралдаан 2004 оны зун болж өндөрлөв. Уралдаанд Халимагийн 100 гаруй хүүхдүүд оролцсон ба ялангуяа бөхөн тархсан нутгийн хүүхдүүд ихээр оролцлоо. Уг уралдаан UNESCO-ийн “Хүн ба шим мандал” хөтөлбөр, People’s Trust for Endangered Species, Дарвиний Санаачлага төслүүдийн хүрээнд санхүүжигдэв.



“Бөхөн хүүхэлдэйн кино” Казахстаны Астанад болсон үзэсгэлэн

Казахстан улсын Астанад 2004 оны 11 сарын 22-26 нд бөхөнгийн тухай хүүхэлдэйн киноны уралдаан болсон ба хамгийн сайн болсон бүтээлүүдийг үзэсгэлэнд тавив. Уг уралдааныг Герман улсын “Хүн ба Байгаль” болон Алмата, Чимкент, Кызыл Орда, Семипалатинск, Новосибирск зэрэг долоон хотын уран бүтээлийн нэгдэл нэгдсэн “Азийн урлаг” (Казахстан) холбоо зохион байгуулав. Энэхүү уралдаанд Чимганы ZHEBE студийн бүтээл ялагчаар тодров. Германы экологич Мартин Ленк толгойлсон “SaigaArt” төслийн найруулсан бүтээл шалгарав. Энэхүү төслийг Shell (Казахстан) ба Германы Global Fund of Nature болон NABU байгуулага санхүүжүүлсэн. Бөхөнгийн тухай хүүхэлдэйн кино нь 2005 онд дэлгэцнээ гарсан.

Францийн телевизээр бөхөнгийн тухай кино үзүүлэв

Өнгөрсөн жил Марафон продакшны киноны багийнхан бөхөнгийн биологичдыг дагалдан Казахстан болон Халимагаар явж кино зураг авсан. Судлаачид хамтарсан судалгааны ажлаа Английн Дарвиний санаачлага болон ИНТАС төслүүдийн санхүүжилтээр хийв. “Aline and the saigas” кино нь 2005 оны 3 сарын 18-20 ны Франц улсын Албертад болсон Зэрлэг амьтны тухай олон улсын 15-р кино фестивалд шалгарлаа. Уг кино шүүгчдийн зүгээс “Prix de la Publique” категориор өндөр үнэлгээ авсан ба олон нийтийн саналаар фестивалийн хамгийн шилдэг гурван киноны нэгээр тодорлоо. Францийн телевизийн Canal+ сувгаар бөхөнгийн тухай киногоо 2004 оны 12-р сард үзүүлэв.

Киноны талаар илүү мэдээлэл авахыг хүсвэл:

<http://www.marathon.fr/detailcat.php?IDFCHE=313&CODELANGUE=UK&IDCAT=9>



Хятад дахь бөхөн сэргээн нутагшуулалт

Хятад улсын засаг захиргаа бөхөнг дахин сэргээн нутагшуулахаар шийдэв. Анхны сэргээн нутагшуулалт 1987 онд Хятад улсын Шинжаны болон Гансу мужуудад хийгджээ. Шинжаны мужид өмнө нь бөхөн тархаж байсан ба харин Гансу муж бол 10 гаруй жилийн турш бөхөнгийн жижиг популяцийг гаршуулж ирсэн Хятадын цорын ганц муж юм. Эдгээр мужууд нь бөхөнг сэргээн нутагшуулах талаар тодорхой төлөвлөгөө байхгүй боловч үүнийг шийдвэрлэхийн төлөө ажиллаж байна.

Бөхөнгийн тухай хэвлэлд

Казахстан ба Монгол

“Новое поколение”, 2004 оны 6 сарын 4

Бөхөнгийн янзаганы тайван байдал

Казахстанд болсон байгаль хамгааллын өдрөөр тал хээрийн бэлэг тэмдэг гэгдэх бөхөн устгах ирмэгт тулсаныг зарлалаа. Казахстан улсын бөхөнгийн популяци арав гаруйхан жилийн өмнө нэг сая тоо толгойд хүрч байжээ. Одоогийн байдлаар дээрхи бөхөнгийн популяци 2 хувьд хүртлээ буурч, тоо толгой нь 20.000 гаруйхан болтлоо цөөрчээ. Бөхөнгийн эвэр нь уламжлалт анагаах ухааны түүхий эд болдог бөгөөд энэ байдал нь тоо толгойн огцом бууралтанд нөлөөлжээ. Казахстан улс 1998 онд бөхөн агнахыг хуулиар хориглосон боловч жил бүр хэдэн арван тонн бөхөнгийн эврийг уламжлалт анагаах ухааны түүхий эд болгохоор Хятад улс руу гаргажээ. Зуун зууны турш бөхөн нь ан агнуурын гол амьтны нэг байсаар ирсэн ба агнуур аюул занал учруулаагүй байжээ. Казахстан улс 1959 онд бөхөн үйлдвэрлэлийн зориулалтаар агнаж эхэлсэн бөгөөд зарим жилд нийт агнасан бөхөнгийн тоо толгой 500.000-д хүрч байжээ. 1993 онд хууль ёсоор гадагш гаргасан бөхөнгийн эврийн экспорт дээд цэгтээ хүрч 60 тонн болтлоо өсчээ. Гэсэн ч бөхөнгийн үйлдвэрлэлийн зориулалттай агналт нь шинжлэх ухааны үндэслэлтэй хийгдэж, хууль бус агнуурыг таслан зогсоодог байсны ачаар бөхөнгийн тоо толгойд аюул занал учруулдаггүй байлаа.



ЗХУ задран унаж, эдийн засгийн хямрал үүсэхийн хамт хүн ба зэрлэг амьтдын хамт оршин байх тэнцвэр алдагдаж эхэлжээ. Нийгмийн хямралаас болж хөдөөний иргэд идэх юмгүй өлсөхийн эрхэнд бөхөн агнах болсон байна. Бөхөнгийн тоо толгой эрчимтэй буурч эхэлмэгц 6 жилийн өмнөөс дахин бүрэн хэмжээний хамгаалалд авчээ. Гэсэн хэдий ч 2001 онд 5000 кг, 2002 онд 18.000 кг, 2003 онд 9000 кг бөхөнгийн эвэр тус тус Хятад улс руу гаргасан байна. Дээр өгүүлсэн Хятад улс руу гаргасан бөхөнгийн эврийн тоо баримтыг “Охотзоопром” (Казахстан улсын ангийн нийгэм)-ийнхэн эдгээр эвэр нь хулгайн анчдаас хурааж авсан, агуулахад олон жил хадгалагдаж байсан, мөн байгаль дээр үхсэн бөхөнгийн сэгнээс цуглуулсан эвэр гэж тайлбарладаг. “Ойн аж ахуй ба анчдын нийгэмлэг” 2003 онд хулгайн ан зөвхөн 16-г илрүүлж 116 бөхөнгийн мах хураан авчээ. Эндээс тооцож үзэхэд нийт агнагдсан бөхөнгийн эвэр ойролцоогоор 9 кг орчим болж байна. Магадгүй, хулгайн ангийн тохиолдол бүгд бүртгэгдэж байна уу? гэсэн асуулт гарч ирж болох юм. Казахстан улсын бөхөнгийн эвэр хадгалдаг агуулахууд 5 жилийн турш хоосон байжээ. Бөхөнгийн эвэр хадгалдаг агуулах 1998 онд сүүлчийн удаа ашиглагдсан ба 1997 онд ердөө 2 тонн орчим бөхөнгийн эвэр гадагшаа гаргажээ.

Нэг байгаль хамгаалагчаас 8 тонн эвэр хураасан тохиолдол ч гарчээ. Хоршооллын хөдөлгөөн 1988 онд үүсч бизнесменүүд “Sinегorie”, “Rostok” зэрэг хоршоолол байгуулан бөхөнгийн эврийг бөөнөөр худалдан авч, 1 кг эврийг 2 хайрцаг энэтхэг цай, эсвэл 1 л архиар сольдог болжээ. Ингэснээр хоршооллынхон нутгийн иргэдийг хууль бус агнуурт татан оролцуулж бөхөнгийн эврийг Хонг Конг, Сингапурт зардаг байжээ. Казахстан улсын Байгаль орчны сайд ноён Анатолий Дубицкийн тушаалаар 1990-1991 онд зохион байгуулагдсан “Бөхөн” ажиллагааны үеэр байгаль хамгаалагчид өөрсдөө Охотзоопромын мотоциклийг ашиглан хулгайгаар бөхөн агнадаг нь тогтоогджээ. Түүнээс хойш байдал бараг өөрчлөгдсөнгүй. Хүмүүс бөхөн хэрцгийгээр хөнөөсөөр л байна. Хэрэв сүүлийн 3 жилд худалдаалагдсан бөхөнгийн эврийн үнийг Хятадын хил дээрхи ханшийг үндэслэн нэг кг-нь 100 ам.доллар гэж үзвэл 3 сая илүү ам.доллар гэсэн тооцоо гарч байна. 1985 оны өөрчлөн шинэчлэлтээс эхлэн 1998 он хүртэл 131 тонн бөхөнгийн эвэр гадагш гаргажээ. Бөхөнгийн эврээс олсон улсын нийт орлогын нийлбэр ойролцоогоор 13 сая ам.доллар болж байна.

Бэлтгэсэн: Галина Наумова

Бүрэн эхээр авахыг хүсвэл дараах сайтаар хандана уу! <http://saigak.biodiversity.ru/publications/naum1.html>

“UB Post” сонин. 2004 оны 4 сар

Судалгаагаар бөхөн мөхлийн ирмэгт тулсныг тогтоожээ

WWF-ийн Монгол дахь салбарын сүүлийн үеийн судалгаагаар Монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*)-гийн популяци 750 тоо толгой хүртлээ буурчээ. Энэ нь 2003 оны XII сард хийсэн популяцийн үнэлгээний дүн юм. Дөрөвхөн жилийн өмнө албан ёсны тооллогоор 5200 тоо толгой гэж гаргажээ. WWF-ийн Монгол дахь хөтөлбөрийн мэргэжилтэн Ё.Онон: “Бөхөнгийн тоо толгойн бууралтанд нөлөөлсөн шууд хүчин зүйл нь хулгайн ан” хэмээн өгүүлжээ. Хулгайн ан болон хууль бус наймаачдын нууц сүлжээ нь бөхөнгийн эврийн наймаа оршин тогтнох нөхцлийг бүрдүүлж байна. WWF-ийн Монгол дахь салбар нь хэд хэдэн хулгайн анчдыг мөрдөн тэд нараас ярилцлага авсан байна. Тэд нар бөхөн агнахдаа машинаар хөөн бахардуулж, мөргөж унагаад амьд байхад нь сүхээр эврийг нь тас цавчиж авдаг ба биеийн бусад хэсгийг нь ашигладаггүй байна. Цөөн хэсэг нь бөхөнгийн махыг хүнсэнд ашигладаг ба ихэнх нь эврийг аваад амьдаар хаядаг нь цус алдан үхэх шалтгаан болдог байна. Хятад худалдан авагч нар амьдаар нь салгаж авсан эврэнд илүү мөнгө төлдөг ба ингэж салгаж авсан эврийн цусны агууламж үхсэний дараах эврийнхээс өндөр байдаг ажээ. Баттай эх сурвалжаас үзэхэд зах дээр бөхөнгийн өрөөсөн эвэр 20.000-30.000 төгрөг (18-27 доллар) байна.



WWF-ийн Монгол дахь салбар бөхөнгийн тархаж болох 2.860 км2 нутагт тооллого судалгаа хийжээ. Судлаачид бөхөнгийн тархац нутгийн хүрээнд хүрээлэн буй орчин, цаг уурын зүгээс нөлөөлөх муу нөлөө байгаагүйг тогтоосон ба тоо толгойн хорогдолд хулгайн ан шууд нөлөөтэй гэж үзэж байна. Мэргэжилтэн Ё.Онон бөхөн хамгаалах ажилд орон нутгийн иргэдийг татан оролцуулах талаар чармайн ажиллаж байна. Мөн хулгайн ангийн эсрэг хууль ёсны арга хэмжээ авахын төлөө ажиллаж байна. “Хуулиар хувь хүн ховор амьтан агнасан тохиолдолд 20.000-50.000 (18-45 ам.доллар) төгрөгний торгууль төлөх ёстой” хэмээн өгүүлж байна. “Энэ хуулийг даган мөрддөг хэдий ч үнэн хэрэгтээ эрүүгийн хариуцлагаас хялбар зайлж байна. Засгийн газар Монгол бөхөн устгах аюулд ороод буй энэ үед бодит арга хэмжээг авах байх гэдэгт бид найдаж байна” гэж Ё.Онон хэлжээ.

Бэлтгэсэн: Б.Булгамаа

Бүрэн эхээр нь авахыг хүсвэл дараах сайтаар хандана уу!
http://www.saigak.biodiversity.ru/eng/publications/ub_post.html

Бөхөнгийн тухай хэвлэлд

Узбекистан

“Правда Востока”, 2004.XI.20

Бөхөнг хамгаалж болно

Хүний үйл ажиллагааны нөлөөгөөр 1972 онд Хунград-Бейнийн төмөр замыг барьснаар бөхөнгийн популяци эрс багассан. Шуудууны дагуу 1060 мм диаметртэй хийн хоолой 1975 онд барилгачид тавьснаар бөхөнд хүчтэй цохилт болов. Хийн хоолой 20-40 км урттай гагнагдсан. Шуудууны дотор хийн хоолойг тавихаас өмнө бөхөнгийн нүүдлийн замд саад болж байсан юм. Бөхөн энэхүү саадыг даван гарахаас бэргэж байсан. Тухайн үед доктор О.П.Богданов Ургагаас хойш 120 км замналд 1000 орчим эр бөхөнгийн сэг тоолжээ. Эдүгээ төмөр замын дагуу Устюртын заман гарц байгаа ч өнөөдөр бөхөнд төмөр зам саад хаалт биш болжээ. Гэвч бөхөнд шинэ аюул байгаа нь Хунград-Бейнийн төмөр

□



Узбекистаны Устюртын зүүн хэсэг дахь зурагтын дахин дамжуулах байгууламж (зүүн талд)

Хунград-Бейнийн үндэсний томоохон төв зам барьж буй байдал (баруун талд)

Зургыг Александр Есипов



Хулгайн анчдыг 3 бүлэгт хуваан үзэж болно. Эхний бүлэгт бөхөнг өөрийн гэр бүлээ тэжээх эсвэл махыг нь зарахын тулд бөхөнг буудаж буй хүмүүс хамаарна. Казакстанд бөхөнгийн махыг 2000-2500 тэнгэ буюу ойролцоогоор 15-20 доллараар зардаг. Казакстан руу явж буй галт тэргэнд мах байнга зарагддаг ба 1 кг мах 1000 соумын буюу ойролцоогоор 1 долларын үнэтэй. Хоёр дахь бүлэгт Хятад руу эврийг нь зарахын тулд бөхөнг буудаж буй хулгайн анчид хамаарна. Бөхөнгийн гурван ооны эвэр 1 кг хүрч ойролцоогоор 300-350 америк доллар болно. Гурав дахь бүлэгт дээд зиндааны хүмүүс сонирхлын үүднээс агнана, ийм анчид хурд хүчтэй машин ашигладаг бөгөөд байгаль хамгаалагч, цагдаа нарын хамт ангуучлана. Харин хулгайн анчдын ихэнх нь ажилгүйчүүд байдаг. Дунджаар 80.000 бөхөнг хулгайн анчид 32 (1972-2004) жилийн турш агнасан байна. 1983 оны 11 сард анх хулгайн анчинг шоронд хорьсон. 1990-1999 оны хооронд 10 гаруй бөхөнгийн хулгайн анчинг ялтнаар татсан. Саяхан Бүгд найрамдах Каракалпакистан, Устюрт улсын Байгаль хамгааллын үндэсний хорооноос шуурхай бүлэг гарч хулгайн анчидыг илчлэх ажлыг эхэлжээ. Нэг байцаагч, 2 туслах ажилтнаас бүрддэг энэ бүлгийн ахлагч нь Бегдула Утепбергенов юм. Бүгд найрамдах Каракалпакистан улсын яамдын танхимын 1991 оны 11 сарын 29 ны № 311/12 тогтоолоор 1 сая га талбайтай Устюртын нутагт бөхөнгийн дархан цаазтай газрыг бий болгохоор тогтсон. Бүгд найрамдах Каракалпакистан улсын байгаль хамгааллын улсын хороо энэхүү дархан газрыг удирдан ажиллаж байгаа ч бодит байдалд зохих үйл ажиллагаа нэгийг ч хийгээгүй, дархан газар байхгүй мэт. Бүтэн жилийн турш засгийн газраар хамгаалагдсан тэр нутагт ч бөхөнг хулгайн анчид буудсаар л байна. Зөвхөн эрдэмтдийн санал зөвлөмж, мэдлэг, төрийн бус байгууллагуудын оролцоо, мэдээллийн хэрэгсэл зэргийн хамтын хүчээр хулгайн анчидыг эсэргүүцэж чадна. Устюртын бүлгийн үндэс суурийг ашиглан шалгалтын бүлгийг яаралтай байгуулах нь чухал шаардлагатай байна. Энэхүү шинэчилсэн шалгалтын бүлэг нь бөхөнг хамгаалахаас гадна устаж буй ховор хөхтөн, шувуудыг хамгаалах зорилго бүхий байгаль хамгааллын нэгэн томоохон идэвхи санаачлагыг бий болгоно. Устюртын ургамлын унаган зүйлүүд ч хамгаалалтанд орох болно.

Эхийг бичсэн: Валентин Бочин

Илүү дэлгэрэнгүй мэдээллийг: <http://pv.uz/?inc=5&news=197> болон <http://kungegrad.narod.ru/4/s.htm> хаягаар авна уу.

ЦЕНТР ДИКИХ ЖИВОТНЫХ
РЕСПУБЛИКИ КАЗАХСТАН

Д. Кугилтинов, Г. Кукарека

В КОЛЫБЕЛИ КОВЫЛЕЙ



Бөхөнгийн талаар сүүлийн үед хэвлэгдсэн нийтлэлүүд

- Д.Кугилтинов, А.Кукарека. 2004. “В колыбели ковылей” (Өдлөг өвсний өлгий нутагт) Элиста. 36 хуудас. Бүгд найрамдах Халимаг улсын Зэрлэг амьтдын төвөөс номыг авч болно. ОХУ, Элиста, 358000, 36 Чкалов гудамж.

- “Бөхөн – мөхлийн ирмэгт гэвч найдах зүйл бий” 2004. Я.Арилов, В.Бадмаев, А.Бекенов, Ж.Чимэг, А.Энтвистл, Я.А.Грачев, Б.Лхагвасүрэн, А.Луцкеина, Д.Маллон, Э.Ж.Милнер Гүүланд, В.Украинский. Огух 38, 250-251.

- “Право на жизнь” (Амьдрах эрх) 2005. Э.Крейзбэрг-Мухина. Степной бюллетень 17, 10-13.

- “Состояние популяций сайгака в Казакстана в 2004 году” (2004 онд Казакстаны бөхөнгийн популяцийн байдал). 2005. Лу.А.Грачев. А.Б.Бекенов, Степной бюллетень 17, 15-16.

- “Цагаан зээр, бөхөн хамгааллын олон улсын зөвлөгөөн” 2005. Кириллюк В, Луцкеина А. Степной бюллетень 17, 17-19.

Өгүүлэл

Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийг ашиглах нь

Айли Канг, Хятадын Зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэгийн хөтөлбөр

Бөхөнгийн эвэр нь бөхөнг Хятадын уламжлалт анагаах ухаанд алдартай болгосноос гадна Ховор зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци, IUCN-ийн ховор зүйлүүдийн жагсаалтанд бичигдэхэд хүргэсэн юм.

Хятадын уламжлалт анагаах ухаан дахь бөхөнгийн эвэр

Хятадад бөхөнгийн эврийн түгээмэл дэлгэрсэн нэр нь Лин ян жиао бөгөөд эм зүйн шинжлэх ухааны нэр нь *Cornu Antelopis* юм. Хятадын уламжлалт анагаах ухаанд хүдрийн заар, бугын чив, хирсний эвэр, бөхөнгийн эвэр нь хамгийн эрхэм, үнэ цэнэтэй түүхий эд болдог. Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийн шинж чанарыг давсархаг, хүйтэн хэмээн тодорхойлон бичсэн байдаг. 1990-2004 он хүртэл хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийн талаар судалсан судлаачдын 161 судалгаа (өгүүлэл) байгаагаас 63 судалгаа (өгүүлэл) нь эмнэлгийн туршилтаар батлагдсан. Тухайн өгүүлэлд дурдсанаар бөхөнгийн эврийг: 1. Өндөр халуурах ялангуяа вирусны халдвараар үүссэн халуунд; 2. Хүүхдийн өндөр халуунд, татахад; 3. Саа өвчний үед; 4. Элэгний хөөрөлтөөс үүсэх даралт ихсэх; 5. Уураг тархины саатал болон тархины бусад өвчин; 6. Багтраа болон хүүхдийн бусад трахейн өвчин зэрэг олон төрлийн өвчний эмчилгээнд ашигладаг байна. Бөхөнгийн эврийг агуулсан 40 төрлийн уламжлалт болон патентын эрхтэй эм, 30 гаруй хятадын уламжлалт эмчилгээний жор байдаг ажээ. “Хятадын эмчилгээний патентын шинэчлэн хэвлэсэн бүтээл” (Song, Guo 2002)-д бөхөнгийн эврийг уушигны болон хүйтний өвчин зэрэгт ашиглах 18 төрлийн эмийн үндсэн түүхий эд болдог гэж бичсэн байдаг. Эмчилгээний өөр нэг арга нь хүмүүс бөхөнгийн эврийг нимгэн хэрчих юмуу нунтаглаад усанд буцалган шууд хэрэглэдэг. Бидний судалсан 30 өгүүлэлд дурдсанаар бөхөнгийн эврийг өвчин эмгэгт ялангуяа ханиад болон өндөр халуунд шууд хэрэглэж болохыг тэмдэглэсэн байдаг.

Бөхөнгийн эврийг орлуулагч

Хятадад түвд гөрөөс (*Pantholops hodgsoni*), түвд зээр (*Procapra picticaudata*), Пржевальскийн зээр (*Procapra przewalskii*), хар сүүлтний (*Gazella subgutturosa*), цагаан зээр (*Procapra gutturosa*), бөхөн (*Saiga tatarica*) зэрэг зээрийн дэд овгийн 6 зүйл байдаг. Эдгээр бүх зүйлийн эврийг “Лин ян жиао” гэж нэрлэдэг. 1990 онд Занг түүхэн бүтээлээс “Лин ян жиао”-г үйлдвэрлэх газар, бөхөнгийн популяцийн түүхэн тархац хоёрыг харьцуулан үзэж “Лин ян жиао”-г Хятадын уламжлалт анагаах ухаанд нэгээс олон зүйлийн амьтдаас гарган авдаг байх магадлалтай хэмээн дүгнэсэн. Хятадад бөхөн байхгүй болсон ч түүний эд, эрхтэн Хятадын уламжлалт анагаах ухаанд өндөр эрэлт хэрэгцээтэй хэвээр байна. Хятад улсын эрүүл мэндийн танхим 1978 оноос хойш цагаан зээр болон хар сүүлтний эврийг орлуулагч болгон ашиглах талаарх судалгааг орон нутгийн хүрээлэнд даалгажээ (Ху, 2003). Хэдийгээр зарим зүйлийг агнахыг хориглосон ховордож буй зүйл боловч хамгийн сайн орлуулагчид нь цагаан зээр, ангорын ямаа, түвд зээр, хар сүүлтний, гэрийн хонь, усны сарлаг юм. Зарим судлаачид бөхөнгийн эвэрний оронд ангорын ямааны турууг ашиглахыг оролдож байсан. Цагаан зээрийг орлуулагч болох талаар анхны хэвлэл 1963 онд хэвлэгдсэн (Ку, 1963). Ихэнх судлаачид нарийвчилсан судалгаа болон харьцуулан судлах асуудал дээр анхаарлаа хандуулж байна. Орлуулагчидад нөлөө үзүүлэхгүйгээр эмнэлгийн туршилыг хийхэд анхаарлаа хандуулж, эм гарган авахад бага анхаарч байгаа юм. Хятадын уламжлалт анагаах ухааны сорил хийгч хүмүүс зэрлэг бөхөнгийн популяцийн устаж буй нөхцөл байдлын талаарх мэдлэг муу байдаг. Тиймээс орлуулагчдын хэрэглээ одоохондоо хөгжөөгүй байна.



Зураг. Г авлын ясны хэсэг бүхий бөхөнгийн эвэр. Фотог Александр Есипов

Хятадын засгийн газрын хүчин чармайлт

Хятадын засгийн газар “Зэрлэг эмийн нөөцийг хамгаалах журам” 1987 онд баталж Хятадын уламжлалт анагаах ухааны нөөцийн хамгаалах дүрэмд бөхөнг хамгийн өндөр зэрэглэлээр хамгаалах зүйл болгон хавсаргасан. 1988 онд Хятадын засгийн газар “Зэрлэг амьтныг хамгаалах хууль”-д бөхөн бол 1-р ангиллын хамгаалагдсан зүйл хэмээн мэдэгдсэн байдаг. Засгийн газар 1987 онд уламжлалт анагаахын улсын захиргаа, улсын ойн захиргаа бөхөн үржүүлэх төвийг барьснаар сэргээн нутагшуулах төслийг эхлүүлсэн.

Хамгааллын асуудал

Бөхөн устаж буй нь зэрлэг амьтдыг хамгаалах үүднээс ч Хятадын уламжлалт анагаах ухаанд ч тэр хамгаалах уриа дуудлага болж байна. Хирсний эвэр шиг Хятадын уламжлалт анагаах ухаанаас “Лин ян жиао”-г үгүй болохыг хэн ч хүсэхгүй байгаа. Байгалийн нөөцийг зохистой ашиглах нь байгаль хамгаалал болон Хятадын уламжлалт анагаах ухаанд хамгийн чухал ойлголт юм. Хамтын ажиллагаа нь бөхөнгийн эзэмшил нутагт түүний популяцийг нөхөн сэргээх, хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийг орлох өөр зүйлийг олоход туслас, хятадад сэргээн нутагшуулах, олон нийтийн мэдээллийг хөгжүүлэхэд чухал нөлөөтэй.

Нэмэлт мэдээлэл ygling@online.sh.cn хаягаар авч болно.

Өгүүлэл

Туркменистан дахь бөхөнгийн өнгөрсөн ба одоогийн байдал

Жумамурад Сапармурадов Туркменистаны Байгаль хамгааллын яамны
Амьтан, Ургамал, Цөлийн үндэсний хүрээлэн

Бөхөн Туркменистаны хойд, баруун хойд хэсгээр болон ихэвчлэн Устюрт, Сарикамишын хойд хэсэг Хара-Богаз голын дагуу тархсан байдаг. Өнөөгийн байдлаар бөхөн цаг агаарын тааламжгүй байдлаас шалтгаалан ихэвчлэн Туркменистанд өвөлждөг. Цас ихтэй зарим жил бөхөн Казакстаны өмнө зүг рүү нүүдэллэн өвөлждөг. Тиймээс Устюртын бөхөнгийн популяцаас Туркменистанд тохиолдож болно. XVII-XIX зуунд бөхөн Устюртын өмнө зүгийн нутгаар тархсан байв. Тэр үед Туркменабадын хойд хэсэг Амударья голын дундуур Хара-Богаз голын зүүн өмнөд хэсэгт бөхөнгийн эзэмшил нутгийн өмнөд хэсэг байжээ. Бөхөнгийн эзэмшил нутаг багасч популяци бууралтанд орсноор 20-р зууны эхний хэдэн арван жилд Туркменистанд бөхөн харагдахгүй болсон. Зарим өвөл буюу 1946-1947 оны цас ихтэй жил бөхөнгийн нүүдэл Туркменистан чиглэсэн байсан. Тэдгээрийн ихэнхи нь Каракумсын баруун өмнө хэсэг рүү нэвтэрсэн ба Копетдагын төв, баруун хэсгээр ганц нэгээрээ тааралдаж байв. Өвлийн нүүдлийн үеэр 1950-иад оны дунд үеэс Туркменистаны баруун хойд хэсэг рүү ихээр нэвтрэн орж байлаа. Бөхөнгийн жижиг популяци Хара-Богаз гол болон Туркмен-Казакын хилийн дагуу хөрш зэргэлдээ нутагт үрждэг. Устюртын популяцийн хэмжээ болон өвлийн цаг агаарын байдал, идэш тэжээлийн хэмжээнээс Туркменистанд өвөлждөг бөхөнгийн популяци хамаарна. Зарим жил баруун хойд хэсэгт өвөлждөг бөхөнгийн популяцийн тоо толгой 25.000 болон түүнээс дээш хэмжээнд хүрнэ. 1965-1966 оны өвөл 40.000 гаруй толгой бөхөн тоологдсон байна. 1984 оны зуны мэдээгээр 30.000 бөхөн Туркменистанд үлдэн хоцорчээ. Сүүлийн хэдэн жилд манай оронд өвөлжиж буй бөхөнгийн популяцийн тоо толгой эрс багасч 2.000-3.000 толгойд хүрэхгүй байна. Зарим жил бөхөн Туркменистан руу нүүдэггүй. Туркменистанд бөхөн ховордон устаж буй, улаан номонд бүртгэгдсэн хаана ч агнахыг хориглосон. Бөхөнгийн өвөлжих эзэмшил нутаг болох Капланкирийн улсын нөөц газар түүний салбар хэсгийг хамгаалалтанд авсан. Өвөл, зун бөхөнгийн эзэмшил нутгийн гол хэсэг болох Казакстаны хилийн ойролцоох Устюртын Хара-Богаз голоос Сарикамиш нуур хүртэлх газрыг хамгаалалтанд авахаар төлөвлөж байгаа юм. Илүү мэдээлэл авахыг хүсвэл: saparmuradov@mail.ru хандана уу.



WWF for a living planet®

Төслийн эргэн тойронд



Бетпақдала (Казакстан) дахь бөхөн хамгаалал

Энэхүү төслийг Франкфуртын амьтан судлалын нийгэмлэг санхүүжүүлж Төв азийн дэлхийн байгаль хамгаалах сангийн хөтөлбөр хэрэгжүүлж байгаа юм. Бетпақдалагийн бөхөнгийн популяцийн бууралтыг зогсоох үндсэн зорилготойгоор 2002 оны зун энэхүү төсөл эхэлсэн. Төслийн үндсэн зорилго нь Казакстан дахь бөхөнгийн популяцийн хамгаалал, нөхөн сэргээлт болон ирээдүйн тогтвортой хэрэглээний тухай асуудал юм. Энэхүү төслийн хүрээнд Казакстан дахь бөхөнгийн унаган популяцийн хууль бус агналтыг нэн даруй зогсоох, популяцийн мониторинг, улирлын байршил нутгийн судалгаа, нүүдлийн замнал зэрэг хамгааллын нэн шаардлагатай практик ажлууд багтана. Бөхөн түүний эзэмшил нутгийг хамгаалахын тулд экологи, нийгэм эдийн засгийн судалгааг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Бөхөн хамгааллын бүхий л хүчин чармайлтыг нэгтгэн үзэх нь чухал бөгөөд бүх хамтрагчид хоёр гэрээнд гарын үсэг зурав.



Нэгдүгээрт, төрийн бус байгууллагуудын олон талт хамтын ажиллагааны тухай бөгөөд ДБХС, ФАЧН (FZS), Лондонгийн эзэн хааны коллеж, Казакстаны ХАА-н яамны агнуурын менежмент болон ойн улсын хороо, Казакстаны ШУ, Боловсролын яамны амьтан судлалын хүрээлэн, Казакстаны Үндэсний хөдөө аж ахуйн их сургууль зэрэг төслийн үндсэн байгууллагуудын оролцоо. Хоёрдох гэрээ нь хоёр талт хамтын ажиллагааны тухай бөгөөд ДБХС, Казакстаны ХАА-н яамны агнуурын менежмент болон ойн улсын хорооны хооронд байгуулагдсан билээ. Засгийн газар санхүүжүүлэн эдгээр байгууллагууд зөвшилцлийн дагуу мэдээллээ солилцон, хоёр талаас гаргаж буй санхүүжилтийг тэнцвэржүүлэн оролцож байна. Төсөл анхнаасаа бөхөнгийн улирлын эзэмшил нутгийг хамгаалан хулгайн ангийн эсрэг тэмцэх техникийн туслалцааг санхүүжүүлсэн. Бөхөнгийн өвөлждөг үндсэн нутаг Андасайскийн хэсэгт төсөл эхэлсэн.

Мониторинг судалгааны дүнд энэхүү газар нутаг ач холбогдлоо цаашид алдах төлөвтэй бөгөөд одоо бөхөнгийн төвлөрөл өөр газар тэмдэглэгдэж байна. Төслийн үйл ажиллагааны хүрээнд Бетпақдалад бөхөнгийн улирлын тархцын дагуу машинаар судалгаа хийж бөхөнгийн ажиглалтын асуудлууд, хулгайн ан дээрх нэргүй мэдээлэл зэрэг нарийвчилсан судалгааг хооронд нь уялдуулан хийсэн (энэ судалгаа нь Дарвины санаачлага төслийн хүрээнд нийгэм эдийн засгийн судалгааны хамт хийгдсэн). Бөхөнгийн өвөл болон хавар-зун бөөгнөрдөг үндсэн нутгуудыг тодорхойлж байгаль хамгаалагчдын баг замналын судалгаа хийх техникийн туслалцааг хүлээн авсан. Бид орон нутгийн иргэд, хүүхдүүдтэй хамтран ажиллаж мэдлэгийг дээшлүүлэх лекц семинар, ханын самбар, товхимол зэргийг хийх ажлыг эхэлсэн.



Бөхөн хамгаалахад хамгийн чухал зүйлийн нэг нь зүй зохистой тоо толгой бүхий популяцитай тусгай хамгаалалтай газар нутгийг бий болгох юм. Бөхөнгийн унаган эзэмшил нутагт шинэ хамгаалалттай газар нутгийг бий болгох үндэслэл гаргахаар Охотзоопротом баг Казакстаны засгийн газраас томилогдон, санхүүжиж бидний төслийн зүгээс дэмжлэг авч байгаа. Бидний гол зорилгын нэг нь шинэ хамгаалалттай газар нутгийг байгуулах үндэслэлийг практик талаас нь зөвлөх юм. Бетпақдала дахь бөхөнгийн тоо толгойг өсгөх зорилгыг зөвхөн манай төслийн үр дүн тодорхойлон гаргаж чадахгүй, харин бүх багийн ерөнхий хүчин чармайлт, Казакстаны засгийн газрын дэмжлэг түүний хариуцлагатай үйл ажиллагаа хэрэгтэй. Энэхүү төслийн талаар нарийвчлан үзэхийг хүсвэл: opereladova@wwf.ru хандана уу.

Төслийн эргэн тойронд



Бөхөн хамгааллыг ашиглан орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах нь

Энэ төсөл нь DEFRA-гийн Дарвины санаачлагын хөтөлбөрөөр санхүүжиж гуравдах буюу сүүлчийн жилдээ хэрэгжиж байна. Гол хамтрагч талууд нь Лондоны эзэн хааны коллеж, Оросын шинжлэх ухааны академийн Экологи эволюцийн хүрээлэн, Казакстаны Амьтан судлалын хүрээлэн зэрэг байгууллагууд юм. Халимагийн зэрлэг амьтан хамгаалах, судалгааны төв, Казакын үндэсний хөдөө аж ахуйн их сургууль, олон улсын Байгаль хамгаалах холбооны (IUCN) бөхөнгийн мэрэгжилтний бүлэг, олон улсын амьтан, ургамал хамгаалах нийгэмлэг (FFI) зэрэг байгууллагууд хамтран ажилладаг.

Төслийн үндэслэл нь устаж буй бөхөнг сүйрлээс аврах, бөхөнгийн хамгааллыг түшиглэн гэр үйлдвэрлэлийг хөгжүүлэн хөдөө нутгийн амьжиргааг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгалийн нөөцийг зүй зохистой ашиглах зэрэг болно. Бид бөхөн төллөдөг унаган нутагт бөхөнгийн үржлийг байнга ажиглах, бөхөнгийн эзэмшил нутагт амьдарч буй хүмүүсийн амьжиргааны түвшинд суурилсан санал асуулгын судалгааг эхлүүлэн хийсэн ба эдгээр судалгаа нь цаашдаа бөхөн хамгаалахад ашиглагдана. Мэдээллийг орос, англи хэлээр дараах хаягаар орж авах бүрэн боломжтой: aline.kuhl@imperial.ac.uk

Бөхөнгийн тархац нутагт байнгын мониторингийн арга зүйг олон нийтэд тараах бодолтой байна. Олон улсын хэмжээнээс орон нутагт мэдээллийг түгээх ажлыг засгийн газар орон нутгийн захиргаатай хамтран гүйцэтгэсэн. Бид Халимаг дахь "Чёрные земли" байгалийн нөөц газартай хамтран хамгаалагч нарыг бэлдэх, тэдний нөхцөл байдлыг сайжруулах, багаж хэрэгслээр хангахад тусалсан. Одоогийн байдлаар Халимагийн хоёр тосгон, Бетпақдалагийн хоёр тосгонд нийгэмийн судалгаа хийгээд байна. Энэ жил бид өөрсдийн ажлаа Устюртад өргөтгөн хийх болно. Халимаг, Устюртад янзагалах үеийн мониторинг судалгаагаа үргэлжлүүлэн хийж байна. Энэ оны сүүлээр бидний судалгааны ажлын үр дүн хэвлэгдэн гарна хэмээн найдаж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу:

e.j.milner-gulland@imperial.ac.uk



Халимаг дахь Таван гашуун тосгоны ард иргэдээс ярицлага авч буй нь. Гэрэл зургийг Лили Кул

Нэн ховор бөхөнгийн Узбекистан дахь тархац нутагт хийсэн нийгэм эдийн засгийн судалгаа

Төслийн зорилго нь Узбекистан дахь бөхөнгийн популяцийн бууралтын нийгэм эдийн засгийн шалтгааныг ойлгоход чиглэв. Олон улсын амьтан, ургамал хамгаалах нийгэмлэгийн (FFI) санхүүгийн дэмжлэгтэйгээр 2004 онд Узбекикийн Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэнгийн эрдэмтэд хийсэн. Харьцуулан судлах зорилготойгоор бид Дарвины санаачлага төслийн арга зүйг нэн ялангуяа хүн амын амьдрах стандарт хэмжээг илрүүлэх санал асуулгын арга зүйг ашиглан бөхөн лүү хандах хандлагыг илрүүлэхийг оролдсон. Судалгаа нь Жаслыкын суурингийн суурьшлын судалгаанд үндэслэсэн.

Гаднаас орж ирсэн ажилчдыг (замын ажилчид, жолооч г.м.) хамруулан Устюртын нутаг болон Узбекикийн хэсгийн бүх суурингийн хүмүүсээс санал асуулга авсан. Судалгааны дүнд Устюртын нутаг, Узбекикийн хэсэгт хүний нөлөө газар тариалан эрхлэх байдлаар давамгайлсан байгааг тогтоосон. Хүмүүсийн ихэнх нь хийн хоолой болон төмөр замд ажиллаж байна. Хулгайн ан бөхөнгийн популяци буурах үндсэн шалтгаан болж буйг илрүүлэн гаргалаа. Бөхөнгийн мах, эврийн өндөр эрэлт хэрэгцээ, хүн амын ядуурал зэрэг нь хулгайн ан хийх үндсэн шалтгаан болж байна. Казакстанд бөхөнгийн мах, эврийг хууль бусаар хил давуулах байдал ихсэж байна. Хууль бус агнуур хамгийн их хийдэг сууринд Жаслык, Каракалпак, Бостан, Кубла-Устюрт зэрэг орж байна.

Асуулга авсан хүмүүсээс хэн нь ч энэхүү дархан газрын талаар сонсоогүй байсан. Мэдлэг боловсролын талаар төслийн хүрээнд орон нутгийн оршин суугчдад хичээл заалаа. Ном хэвлэх, сургуулийн хүүхдүүдтэй уулзах зэрэг ажлууд үндд багтаж байгаа юм. Узбекистаны бүгд найрамдах улсын Байгаль хамгаалах улсын хороонд Узбекикийн Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр гарч буй үр дүн дээр үндэслэн Узбекистанд бөхөн хамгаалах ажлын чиг хандлагыг тодорхойлон өглөө. Дараах гол үйл ажиллагаанууд нэн түрүүн хийгдэх ёстой гэж үзлээ. Үүнд: бөхөн хамгаалах онцгой үүрэг бүхий байгууллага бий болгох, Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах зорилгоор хоёр улсын (Казакстан-Узбекистан) дунд хамгаалалттай газар нутгийг бий болгох, бөхөн хамгаалах арга хэмжээний тухай Казакстаны бүгд найрамдах улстай хамтарсан гэрээнд гарын үсэг зурах зэрэг асуудлууд орж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл:

esip@tkt.uz

Байгаль хамгаалал, менежментийн талаар орон нутгийн хүмүүсийн мэдлэг хомсоос шалтгаалан хулгайн ангийн илрүүлэлт, түүний эсрэг мэдээлэл бага байгаа юм. "Сайгачный" хэмээх дархан цаазат газрыг 1991 онд Каракалпакстан дахь Устюртын хойд хэсэгт байгуулсан ч бөхөн хамгаалах үүргээ биелүүлдэггүй байна.



Узбекистан дахь Жаслык тосгоны орон нутгийн хүмүүс Бөхөнгийн эврийг ашигладаг уламжлалыг судлах судалгаа.

Гэрэл зургийг Александр Есипов



Бөхөнгийн мах, эврийн өндөр эрэлт хэрэгцээ, хүн амын ядуурал зэрэг нь хулгайн ан хийх үндсэн шалтгаан болж байна. Казакстанд бөхөнгийн мах, эврийг хууль бусаар хил давуулах байдал ихсэж байна. Хууль бус агнуур хамгийн их хийдэг сууринд Жаслык, Каракалпак, Бостан, Кубла-Устюрт зэрэг орж байна. Байгаль хамгаалал, менежментийн талаар орон нутгийн хүмүүсийн мэдлэг хомсоос шалтгаалан хулгайн ангийн илрүүлэлт, түүний эсрэг мэдээлэл бага байгаа юм. "Сайгачный" хэмээх дархан цаазат газрыг 1991 онд Каракалпакстан дахь Устюртын хойд хэсэгт байгуулсан ч бөхөн хамгаалах үүргээ биелүүлдэггүй байна. Асуулга авсан хүмүүсээс хэн нь ч энэхүү дархан газрын талаар сонсоогүй байсан. Мэдлэг боловсролын талаар төслийн хүрээнд орон нутгийн оршин суугчдад хичээл заалаа. Ном хэвлэх, сургуулийн хүүхдүүдтэй уулзах зэрэг ажлууд үндд багтаж байгаа юм. Узбекистаны бүгд найрамдах улсын Байгаль хамгаалах улсын хороонд Узбекикийн Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр гарч буй үр дүн дээр үндэслэн Узбекистанд бөхөн хамгаалах ажлын чиг хандлагыг тодорхойлон өглөө. Дараах гол үйл ажиллагаанууд нэн түрүүн хийгдэх ёстой гэж үзлээ. Үүнд: бөхөн хамгаалах онцгой үүрэг бүхий байгууллага бий болгох, Устюртын бөхөнгийн популяцийг хамгаалах зорилгоор хоёр улсын (Казакстан-Узбекистан) дунд хамгаалалттай газар нутгийг бий болгох, бөхөн хамгаалах арга хэмжээний тухай Казакстаны бүгд найрамдах улстай хамтарсан гэрээнд гарын үсэг зурах зэрэг асуудлууд орж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл: esip@tkt.uz

Нэн ховор бөхөнгийн нөхөн үржихүйн экологи

Энэ төсөл нь INTAS-аар санхүүжин Лондоны эзэн хааны коллежийн удирдлагын дор Норвегийн Ослогийн их сургууль, Узбекистаны Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэн, Казакын үндэсний хөдөө аж ахуйн их сургууль, Халимагийн зэрлэг амьтдын хамгаалал, судалгааны төв, Казакстаны амьтан судлалын хүрээлэн, Оросын Шинжлэх Ухааны Академийн Экологи, эволюцийн хүрээлэн хамтран ажиллаж байна. Гурван жил үргэлжлэх төслийн 2 дахь жил нь дөнгөж эхэлж байна.



Цусны дээж авч байна. Гэрэл зургийг Анна Лушекина

Төслийн гол зорилго нь бөхөнгийн нөхөн үржихүйн үеийн зан төрх болон нөхөн үржихүйд хүний үзүүлж буй сөрөг нөлөөг тодорхойлох, үржихүйн мониторинг судалгаанд үндэслэн үр өгөөжтэй шинжлэх ухааны үндэслэлтэй эрсдэлгүй хөтөлбөр бий болгоход оршино. "Чёрные земли" байгалийн нөөц (Оросын холбооны улсын Халимаг дахь) газар, Устюртын (Казакстан-Узбекистан) бөхөнгийн сүргийн хүйсийн ялгаа, нөхөн үржихүйн зан төрхийн мониторинг судалгааг хийж байна. Бид мөн түүнчлэн CSCWAK дахь бөхөнгийн үржлийн сүргийг түшиглэн ялгадас дахь гормоныг ашиглан хээл авсан эсэхийг тодруулах арга зүйг боловсруулсан. Энэ жил үржлийн сүргийг ашиглан зарим шинжүүрийг илрүүлэн гаргаж байна. Дараагийн жил "Чёрные земли" байгалийн нөөц газарт зэрлэг амьтдаас авсан дээжийг байгальд нь шинжилж, эх төлийн харьцааг тодруулна. Хэрэв төсөл амжилттай хэрэгжвэл хээлтэй эм амьтныг барих эсвэл алахгүйгээр, мөн янзага:эм амьтны харьцааг байгальд илрүүлэхэд гардаг алдаагүйгээр нөхөн үржихүйн мониторингыг амжилттай хийх боломжтой болно. Казакстан, Узбекистаны амьтан судлалын хүрээлэн хоорондын хамтын ажиллагааны үр дүнд Устюрт дахь хилийн хоёр талын бөхөнгийн тархалт, одоогийн байдлын талаар анхны судалгааны харьцуулсан судалгааны материалыг цуглуулж байна. Энэхүү мэдээлэл бөхөнгийн улирлын байршил, тархалт хаана байгааг, ирээдүйд хил дамнан хаана байх төрхийг бидэнд өгөх чухал зүйл юм. Илүү дэлгэрэнгүй мэдээлэл хэрэгтэй бол: e.j.milner-gulland@imperial.ac.uk хаягаар холбоо барина уу.

